



ЭМ, ЭМНЭЛГИЙН ХЭРЭГСЛИЙН ХЯНАЛТ,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ

2022 оны 10 сарын 06 өдөр

Дугаар 4/186

Улаанбаатар хот

Шалгалт тохируулгын анализатор,
симуляторт баталгаажуулалт хийлгэх үйл
ажиллагааг зохион байгуулах тухай

Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.3.1, 8.3.7, 8.4, Захиргааны ерөнхий хуулийн 40 дүгээр зүйлийн 40.1, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.1, 16.5.2, 16.5.5, Эрүүл мэндийн сайдын 2015 оны 249 дүгээр тушаалын хавсралтаар батлагдсан “Эмнэлгийн тоног төхөөрөмжид шалгалт тохируулга хийх журам”-ын 4.5, 4.6 дахь хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Эмнэлгийн тоног төхөөрөмжийн шалгалт тохируулгын үйл ажиллагааг үнэн зөв хийж гүйцэтгэх зорилгоор 14 нэр төрлийн 24 анализатор, симуляторыг Америкийн Нэгдсэн Улсын Флюке Биомедикал компаниар баталгаажуулах явцад цахилгааны аюулгүй байдлын анализаторт гэмтэл илэрсэн тул, засвар үйлчилгээ хийлгэх ажлыг зохион байгуулахыг Эмнэлгийн тоног төхөөрөмжийн газар (Р.Энхсүрэн)-т даалгасугай.

2. Дээрх ажилд шаардагдах зардлыг холбогдох зардлаас гаргахыг Санхүү, төсвийн асуудал хариуцсан ахлах мэргэжилтэн (А.Болор-Эрдэнэ)-д зөвшөөрсүгэй.

3. Анализатор, симуляторын гаалийн бүрдүүлэлт хийж, хүлээн авах ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг хавсралтаар баталж, ажлын хэсгийг нэгдсэн удирдлага, зохион байгуулалтаар хангаж ажиллахыг ажлын хэсгийн ахлагч (Р.Энхсүрэн)-д үүрэг болгосугай.

4. Анализатор, симуляторын хэвийн найдвартай ажиллагааг ханган ажиллахыг Эмнэлгийн тоног төхөөрөмжийн газар (Р.Энхсүрэн)-т даалгасугай.

5. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Захиргаа, удирдлагын газар (Л.Батзориг)-т даалгасугай.

ДАРГА



Д.НАРАНТУЯА

1422

01185

Эм, эмнэлгийн хэрэгслийн хяналт,
зохицуулалтын газрын даргын 2022 оны
10 дугаар сарын 06-ны өдрийн
дугаар тушаалын хавсралт

АНАЛИЗАТОР, СИМУЛЯТОРЫГ ХҮЛЭЭН АВАХ
АЖЛЫН ХЭСГИЙН БҮРЭЛДЭХҮҮН

Ахлагч:

Эмнэлгийн тоног төхөөрөмжийн газрын
дарга

Нарийн бичгийн дарга:

Нийслэлийн эрүүл мэндийн байгууллагын
эмнэлгийн тоног төхөөрөмжийн шалгалт
тохируулгын асуудал хариуцсан
мэргэжилтэн

Гишүүд:

Санхүү, төсвийн асуудал хариуцсан ахлах
мэргэжилтэн

Орон нутгийн эрүүл мэндийн байгууллагын
эмнэлгийн тоног төхөөрөмжийн шалгалт
тохируулгын асуудал хариуцсан
мэргэжилтэн

Нярав

--ooOOoo--